

# ХДХВ (Хүний Дархлал Хомсдолын Вирус)

**30**



Олон оронд хүмүүс ХДХВ-ээс болж ДОХ туссан байна. Сайн ажиллаж амьдрах нөхцөлтэй, зөв эм ууж хэрэглэсэнээр ДОХ-той хүмүүс эрүүл байж чадна. Аюулгүй аргаар бэлгийн харьцаанд орох, вирус халддаггүй замаар хавьтах, тогтмол ДОХ-ын шинжилгээ өгөх, ДОХ-ын талаар боловсрол, урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг үйлдвэрт хэрэгжүүлэх зэргээр ДОХ-ын халдвартай ажилчдыг ажиллах чадвартай л байгаа бол тэдэнд тусалж халдварыг тархаахгүй байж чадна.

Ажилчид нь үйлдвэр дээр ихэнх цагаа өнгөрүүлдэг тул үйлдвэрүүд нь дараах зүйлсийг багтаан ДОХ-ын өргөн хүрээг хамарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэй:

- ДОХ-ын шинжилгээг ажлын бус цагаар авах, үнэгүй шинжилгээнд хамруулах;
- ДОХ-той гэдэг нь тогтоогдсон ажилчдыг ялгаварлан гадуурхахгүй байх журамтай байх;
- Ажлын байран дахь гэмтэл, ослоос шалтгаалж халдвар авч болох эрсдэлийг багасгах аюулгүй байдлын сургалт зохион байгуулах;


- ДОХ-той ажиллагчдад өөрийн эрүүл мэнд болон гэр бүлийнхнийхээ эрүүл мэндэд анхаарал тавих чөлөө өгөх;
- ДОХ-оос урьдчилан сэргийлэх талаар болон түүнийг бусдад халдаах, дамжуулахгүй байх талаар, ДОХ-ын талаар зөвлөгөө, шинжилгээ, эмчилгээг бүх ажилчдад болон тэдний гэр бүлд хүртээмжтэй болгох;
- Аюулгүй бэлгийн хавьтарт буюу үнэгүй бэлгэвчний тухайд аян зохион байгуулж дэмжих.

## ДОХ-ЫН ТАЛААР ТА ЮУ МЭДЭХ ХЭРЭГТЭЙ ВЭ

ДОХ (дархлааны олдмол хомсдол) нь ХДХВ (хүний дархлал хомсдолын вирус)-ээс үүсдэг. ДОХ эмчилгээгүй ч туссан хүмүүс РЭЭ (ретровирусын эсрэг эмчилгээ) эмийг хэрэглэж, шаардлагатай үед эмнэлгийн тусlamж авч, шим тэжээллэг хоол хүнс идэж, цэвэр ус ууж, боломжийн орон сууцтай, бас сэтгэл санааны болон сүсэг бишрэлийн дэмжлэгтэйгээр урт удаан эрүүл амьдарч чаддаг болсон.

Эмчилгээгүй орхивол ДОХ нь биенийн дархлаа буюу биенийн хэсэг бүрт өвчин, халдвартай тэмцэхэд тусалдаг системийг устгадаг. Хэт их ажиллах, хоол тэжээлийн дутагдал, зарим химиин бодист өртөх, өвчин зэрэг нь дархлааны системийг сулруулдаг. Эмчилгээ хийж сайн асрахгүйгээр орхивол ДОХ-той хүмүүс ихэвчлэн эрүүл мэндийн асуудал, өвчлөлөөс болж маш их өвдөх буюу сурьеэ, уушгины үрэвсэлтэй болдог. Хүний дархлааны систем маш сул дорой болж цаашид өвчинтэй тэмцэх чадваргүй эсвэл эдгэрэх чадваргүй болох үед хүн нас бардаг. Гэвч ДОХ-ыг эрт илрүүлж, эмчилгээ хийж эхэлсэн бол ХДХВ-ээс сэргийлэх боломжтой.

ДОХ-той хүмүүс эрүүл чийрэг байдлыг мэдэрч, бас эрүүл харагдаж чадна. ДОХ-гүй хүн ч гэсэн заримдаа ДОХ-той хүнтэй адил шинж тэмдэгтэй байж болдог. Тухайн хүнийг ДОХ-той гэдгийг тогтоох цорын ганц арга нь шинжилгээ юм.




---

Ажил хийсэн үедээ би гэртээ хоол хүнс, эмтэй байж чадна. Бид эмчилүүлж чадаж байвал эрүүл ажилтнуудтай адил удаан хөдөлмөрлөж чадна.

---

## ДОХ-ЫН ШИНЖ ТЭМДЭГ

ДОХ-той хүмүүст ямар нэгэн өвчний шинж тэмдэг илэрч эхлэхээс өмнө олон жил болж болно. Анхны шинж тэмдэг нь ихэвчлэн дараах байдлаар илэрдэг:

- Тунгалгийн булчирхай томорч, хүзүү, суга, бэлэг эрхтэн дээр мэдрэгдэх;
- Байнга халуурах ба шөнийн цагаар хөлрөх;
- Турах;
- Ядрамтгай болох;
- Хоолны дуршил буурах;
- Суулгалт;
- Аман дээр цагаан цэг (толбо) гарах;
- Эмэгтэйчүүдэд утрээний идээт халдвартогтмол гарах.

Эдгээр шинж тэмдэг бусад өвчинөөс болж үүссэн байж болно. Эдгээр шинж тэмдэг анх илрэх үед ДОХ-ын шинжилгээ өгөх нь хүч чадалтай байгаа дээрээ эрт илрүүлж, эмчилгээ хийж эхлэх боломжийг олгоно.

## ДОХ хүнээс хүнд хэрхэн халддаг вэ

ДОХ нь цус, үрийн шингэн, утрээний чийг, бас хөхний сүү гэсэн биеийн шингэнд амьдрах чадвартай байдаг. Халдвартай хүний эдгээр шингэний аль нэг нь нөгөө хүний биед нэвтрэхэд халдварладаг. Энэ нь дараах нөхцөлд тохиолдож болно:




**ДОХ-той хүнтэй  
бэлгэвчгүйгээр  
бэлгийн хавьталд  
ороход;**




**Хүний арьсыг  
зүү эсвэл зохих  
ёсны цэвэрлэгээ  
хийгээгүй багаж  
хэрэгслээр цоолох  
эсвэл зүсэхэд;**



**ДОХ-той хүн  
жирэмсэн бол  
эсвэл жирэмсэн  
үедээ вирусийн  
халдварт  
авбал хүүхдэд  
халдварладаг. ДОХ  
нь мэн хөхөөр  
хооллоход халдаж  
болно;**



**Халдвартай хүний цус  
гоожих эсвэл бусад  
ил шархаар дамжин  
нөгөө хүнд халдаах;**



**ДОХ-ын шинжилгээнд  
ороогүй цус сэлбэлтээс  
ДОХ-ын халдвар авч  
болно.**

ДОХ-ын вирус нь хүний биеийн бусад шингэн болох хөлс, нулимс, шүлсэнд амьдрахгүй. Энэ нь биеэс гадуур хэсэгт амьдарч чадахгүй ба агаарт эсвэл усанд хэдэн минутаас илүү байж чаддаггүй.

### Дараах байдлаар ДОХ халдварлахгүй:

- Аяга, таваг, сандал, багаж, радио станц, утас хуваалцах;
- Хоол болон уух зүйл хуваалцах;
- Биеэр хүрэлцэх, шүргэлцэх, тэврэх эсвэл үнсэх;
- Найтаалгах эсвэл ханиах (ДОХ нь сүрьеэз эсвэл ханиад шиг халддаггүй)
- Шумуул хазах (ДОХ нь хумхаа өвчин шиг халддаггүй)

### Эмэгтэйчүүд илүү их эрсдэлтэй байдалд байдаг

Эмэгтэйчүүд өөрсдийгөө ДОХ болон бусад бэлгийн замын халдварт өвчнөөс (БЗХӨ) хамгаалах нь эрэгтэйчүүдийг бодвол илүү хэцүү байдаг. Үйлдвэрийн дарга нар, эр нөхөр, найз залуу нь эмэгтэйчүүдийг дуулгавартай байна гэсэн хүлээлтгэй байдаг. Эрэгтэйчүүд ихэвчлэн эмэгтэйчүүд хэрхэн бэлгийн эрүүл мэндийн талаар санаа зовж байгааг сонсох хүсэлгүй байдаг. Эрэгтэй хүн бэлгэвч хэрэглэхээс татгалзах үед эмэгтэйчүүд бэлгийн хавьтлыг эсэргүүцэх тал дээр хүчгүйддэг.

Хүчирхийлэл, бас бэлгийн халдлага нь эрчүүдээс илүү эмэгтэйчүүдэд хор хөнөөлтэй байдаг. Хүчээр бэлгийн хавьтальд ороход эмэгтэй хүний бэлэг



**Бэлгэвчийг тогтмол  
хэрэглэснээр өөрийгөө  
болон хамтрагчаа  
ДОХ, бусад БЗХӨ-өөс  
хамгаалахад тустай.**

эрхтэн ихэвчлэн гэмтдэг. Хэрвээ халдаж байгаа хүн нь ДОХ-той бол эмэгтэй хүний бэлэг эрхтний урагдалтаар дамжин илүү амархан халддаг (Хүчирхийлэлд өртсөний дараах анхны тусламж хэсгийг 427-428 дугаар хуудаснаас үзнэ үү).

Бэлгэвч хэрэглэхгүй байх нь бусад БЗХӨ тусах магадлалыг ихэсгэдэг. БЗХӨ-тэй байснаар бэлэг эрхтэнд ихэвчлэн ил цэврүү үүсгэдэг тул ДОХ тусах магадлалыг нэмэгдүүлдэг. Бэлгийн замын халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх тухай мэдээллийг 507-509 дүгээр хуудаснаас үзнэ үү.

## ДОХ-ЫН ШИНЖИЛГЭЭ

Хэн нэгэн нь ДОХ-той гэдгийг итгэлтэйгээр мэдэх цорын ганц арга нь шинжилгээ өгөх явдал юм. Үүнд хоёр төрлийн шинжилгээ байдаг. Вирусний шинжилгээ үнэтэй байдаг ч таны цусан дахь вирусийг нарийн үзэж шалгах ба шинжилгээний хариу гарахад хугацаа шаарддаг. Түргэвчилсэн шинжилгээ нь хямд бөгөөд ДОХ-д үзүүлэх биеийн хариу урвалыг судалж, ганц цагийн дотор шинжилгээний дүн гардаг.

Вирус биед орсны дараа шинжилгээгээр илрэх хүртлээ 1-3 сар болдог. Хэрвээ та ДОХ-ын халдварт авсан байж магадгүй гэж бодож байгаа боловч шинжилгээ нь халдвартай шинж тэмдэг харуулахгүй байгаа бол 3 сарын дараа дахин шинжилгээ өгөөрэй. Ургэлж бэлгэвч хэрэглэ. Хэрвээ вирус таны биед байгаа бол энэ нь шинжилгээгээр илрэх болоогүй байсан ч нэг хүнээс нөгөө хүнд халддаг.

Олон оронд түргэвчилсэн шинжилгээ үнэгүй байдаг. Хэрвээ хүн ДОХ-ын түргэвчилсэн шинжилгээгээр эерэг гэж гарсан бол эмнэлэг, эрүүл мэндийн ажилтан итгэлтэй байхын тулд вирусний шинжилгээ хийх болно.

ДОХ-ын шинжилгээ нь дараах байдлаар хийгдэнэ:

- Үнэгүй эсвэл хямд;
- Сайн дурын – хэн ч таныг ДОХ-ын шинжилгээг хүчээр өгүүлэхгүй байх ёстой;
- Нууцлтай – үр дүнг зөвхөн шинжилгээ өгсөн хүнд өгөх болохоос даргад өгч болохгүй.



## **ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГ ХЭСЭГ**

Эмнэлгүүд шинжилгээ хэрхэн хийгддэг, бас шинжилгээний өмнөх үеийн талаарх асуултуудад хариулж зөвлөгөө өгдөг. Хариу бэлэн болоход зөвлөгч тантай буйдхан газар уулзаж, тэдгээрийг тайлбарлана. Хэрвээ хариу таныг ДОХ-той гэдгийг харуулж байвал тэр танд орон нутгийн дэмжих бүлэг болон үйлчилгээ, бас эмчилгээ, эмнэлгийн талаар мэдээлэл өгөх болно. Мөн түүнчлэн ДОХ нь эдгэшгүй өвчин боловч та үүнийг зохицуулж, илүү эрүүл, идэвхтэй амьдарч чадна.

### **Орон нутгаасаа дэмжлэг авах**

Өвчтэй хэн бүхэнд дэмжлэг, хайр, гэр бүлийн, хамтран ажиллагчдын болон олон нийтийн ойлголцол байвал түүнд илүү дээр байж, бас сайжирч, эдгэрч чадна. ДОХ-той хүмүүст дэмжлэг хэрэгтэй. Тэдэнд сайхан сэтгэлээр хүндлэлтэй хандаж, үнэгүй эмчилгээ болон ажлын байранд нь илүү сайн ажлын нөхцөл санал болгож, хов жив эсвэл цуурхал тараах болон ялгаварлан гадуурхахын эсрэг тэмц.

## **ДОХ-ЫГ ХЯНАХ ЭМҮҮД**

ДОХ-ын шинжилгээ нь эерэг гэж гарсан даруйд ДОХ-ын эмчилгээний хөтөлбөр хай. Эдгээр хөтөлбөр нь таныг эрүүл байхад хэрэг болох нөөцөөр хангах болно. Ретровирусын эсрэг (ART) эм хэрэглэснээр дархлааны систем ДОХ-ын вирустэй тэмцэж, таны биеийг хүчтэй байлгах боловч маш бага хэмжээний ДОХ-ын вирус биед үргэлж нуугдан үлддэг.

ART-ыг хэрэглэнэ гэдэг нь дор хаяж 3 төрлийн ретровирусийн эсрэг эмийг хослуулан өдөр бүр хэрэглэнэ гэсэн үг. Эмийн олдоц нь хаана амьдарч байгаагаас хамаарч янз бүр байх болно. Тэдгээрийг нэг бол бүгдийг нийлүүлэн нэг хавтгай эм болгосон эсвэл 3 тусдаа хавтгайгаар байж болно. Гэвч хаана ч адилхан байдаг зүйл гэвэл та нэгэнт ART-ыг хэрэглэж эхэлсэн бол эмийг өдөр бүр тогтмол цагт уух ёстой. ART-ыг ууж байгаа хүн жин нэмж, илүү эрүүл харагдах болно. Гэвч тэр хүн ART-ыг хэрэглэхээ зогсоож эсвэл эмийн тунг алдагдуулж, аль эсвэл буруу цагт уувал ДОХ идэвхжиж, дахин өвчлүүлэх болно.

Жирэмсэн ДОХ-той эмэгтэй ч бас ART-ыг уух хэрэгтэй. Энэ нь тэднийг эрүүл байлгаж, хүүхдийг нь ДОХ-той төрөхөөс хамгаалдаг.

Өөр нэг эм буюу кортимоксазол гэдэг эмийг халдвараас урьдчилан сэргийлэхээр өдөр бүр ууж болно. Кортимоксазол нь ДОХ-ын эмчилгээний хөтөлбөрийн нэг хэсэгт ордог.

ART нь илүү олдоцтой, бас хямд болсоор байна. Улсын эмнэлэг болон үйлдвэрийн эмнэлгүүд ART-ыг хямд үнээр эсвэл үнэгүй санал болгож болох юм.

## Үйлдвэр дэх ДОХ

ДОХ-той хүмүүс ажлын байр эсвэл орон нутагтаа бусдын доромжлолтой нүүр тулснаар эмчилгээ авч, эрүүл амьдрахад илүү хүнд болдог. Хүнийг гутаан доромжилно гэдэг нь сөрөг бодол, итгэл үнэмшил, уур амьсгал, бас хүмүүсийн зүгээс ДОХ-той хүнд хандах зан төрхийн хэлбэр юм. Гутаан доромжлох үйлдэлд хүнийг бусдын нүдэн дээр шившиг болгох, доромжлох, бас ДОХ-той хүний талаар хов жив тараах, бүүр тэдний эсрэг хүчирхийлэл үйлдэх явдал багтдаг. Гутаан доромжлох үйлдэл нь ДОХ-ын талаарх ташаа мэдээлэл болон айдсаас үүсэлтэй байдаг ба хүмүүсийг ДОХ-ын талаарх үнэн байдлаа нуухад хүргэдэг.

ДОХ-той ажилчдыг дарга нь ялгаварлан гадуурхдаг. Зарим газар ажил олгогчид нь ажилд авахаас өмнө ДОХ-ын шинжилгээ өгөхийг шаарддаг. Бусад нь ДОХ-той эсвэл ДОХ-той гэж бодсон ажилтнаа халдаг. ДОХ-той ажилтан ажилд орж эсвэл ажлаа хадгалж үлдэж чадахгүй байх үед тэдний хувьд эрүүл байж үйлчилгээ авах боломж нь улам багасдаг.




**ДОХ-ын талаарх айдас нь хүмүүсийг өөрсдийн болон бусдын эрүүл мэндэд санаа тавихад саад болсоор байна.**

ДОХ-той хүмүүс ажилласаар байгаа үйлдвэрүүдэд тэд эрүүл мэндийн даатгалгүй, цалин хөлсийг нь нэмэхгүй, тушаал дэвшигүүлэхгүй, бүүр бие засах газар хэрэглэхэд зөвшөөрөл авах хүртэл ялгаварлан гадуурхах явдалтай нүүр тулдаг. Ялгаварлан гадуурхлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг 21-р бүлгээс үзнэ үү.

## Дасгал

## ДОХ ажил дээр халдварлахгүй

1. Бүлгээ хос болгон хувааж тэднээс ДОХ үйлдвэрт тархах айдсын талаар хэлэлцэнэ үү гэж хүс. Тэд өөрсдийн айдсаа хэлж, бас самбар дээр бичүүлнэ. Хэрвээ шаардлагатай бол хэлэлцүүлгийг эхлүүлэхэд тус болох санааг бэлэн байлга.
2. Айдсын жагсаалтаас сонгож дүрд тоглуул (хэрхэн дурд тоглох талаар 425-р хуудаснаас үзнэ үү). Жишээлбэл, хэрвээ хэн нэг нь “гар барих”-аас айж байвал ДОХ-той хүнтэй түүний ахлах нь гарцаа сунган гар барьж мэндлэх дүрд тогло. Тухайн хүн юу хийх вэ? Яагаад хүмүүс ДОХ-ын халдвар нь гар хүрснээр халдана гэж боддог вэ? Хүмүүсийн айдсын ард яг юу нуугдаж байгааг тэднээр хэлүүл.



**3.** Өмнөх хуудаснаас ДОХ-ын талаарх мэдээллийг бүлгээрээ дахин үзэж, ДОХ яаж хүнээс хүнд халдвартадаг, бас ямар замаар халддаггүй тухай хэсэгт анхаарлаа хандуул. Эдгээр жагсаалт болгонд тохирох үйлдэл нь ДОХ-ыг халдвартлуулна гэж бодсоор байгаа эсэхийг асуу.

**ТЭМДЭГЛЭЛ:** Дээрх жагсаалтаас “хурц эд зүйлс” нь ДОХ-той хүн гэмтэж, цус гаргасан үед халдварт авч болох цорын ганц зүйл юм. Хэрвээ энэ нь таны хэлэлцүүлэгт гарч ирсэн бол ДОХ яаж цусанд хүрэхэд халддаг болох, бас бээлийн эсвэл гялгар уутны тусламжтайгаар халдвараас хэрхэн урьдчилан сэргийлж болох талаар ярилц. Цус алдаж байгаа ажилчинд хэрхэн аюулгүйгээр туслах аргуудыг 272-р хуудаснаас үзнэ үү. Хүчиндүүлсэн эсвэл бэлгийн харилцаанд албадлагаар орсон хүмүүс мөн ДОХ-ын халдварт авах эрсдэлтэй. Хүчирхийлэлд өртсөний дараах анхны тусламж хэсгийг 427-428 дугаар хуудаснаас үзнэ үү.

## Дасгал

### ДОХ хөдөлмөрийн бэрхшээл болохоос чадваргүй гэсэн үг биш

ДОХ-той ажилтан бусдыгаа эрсдэлд оруулалгүйгээр үргэлжлүүлэн ажиллаж чадна. Бусад хөдөлмөрийн бэрхшээлийн адил ДОХ-той хүмүүсийн ажлын байрыг аюулгүй болгох боломжтой. Хэт их ажиллах, аюултай багаж хэрэгсэл, бохир бие засах газар, чанар муутай хүнс, агууржуулалт дутмаг байдал болон бусад ажиллагчдын асуудал буюу эдгээр аюул нь ялангуяа ДОХ-той ажилтанд илүү их хор нөлөөтэй байдаг. ДОХ-той хүмүүс нь илүү амархан өвчтэй болдог тул нийтлэг өвчнөөс болж амия алдах магадлал их байдаг. ДОХ-той ажиллагчдын нөхцөлийг сайжруулнаар бүх ажилчид сайн нөхцөлд ажиллах болно.

1. Үйлдвэрт ажиллагчдын нүүр тулж байгаа аюулзуудын жагсаалтыг гарга.
2. Жагсаалтыг доош явуулан эрүүл ажилтантай харьцуулахад ДОХ-той ажиллагчдад аюул бүр нь хэрхэн



нөлөөлөх талаар харьцуулан асуу. Энэхүү үйл ажиллагааг ашиглан зарим аюул нь хэрхэн жирэмсэн эмэгтэйчүүд, бие эрхтний эсвэл сэтгэцийн бэрхшээлтэй, бас бусад эмзэг ажиллагчдад нөлөөлж болох талаар ярилцаж болно.

	Эрүүл ажилтан	ДОХ-той ажилтан
Тоног төхөөрөмжийн гэмтэл	Өвдөх, гэмтэх, таслагдах	Эрүүлтэй адил. Бусад ажилтнууд халдварт авч болно. Магадгүй хэн ч туслахыг хүсэхгүй байж болно.
Химиин бодис болон тоос	Цочрол, астма, ханиалгах	Эрүүлтэй адил. Дархлааны систем. Илүү өвчтэй болж болно.
Хэт их ажиллах	Ядарсан, туйлдсан, стресстэй	Адилхан. Илүү өвчтэй болж болно
Усгүй байх	Бүх хүнд ус хэрэгтэй	Биеийн шингэнээ илүү хурдан алдана
Жорлон	Бохирдол нь бүх хүнийг өвчлүүлдэг	Тэд жорлонгийн эсвэл үснэ нянгаас болж маш хүнд өвчтэй болж амиа алдахад хүрч болно.
Сайн хооллох	Өлсөх, ядрах, толгой эргэх	Эрүүлтэй адилхан. Хангалттай хоол идээгүйгээс маш хүнд өвчтэй болж болно.
Сүрьеэ	Маш хүнд өвчтэй болж. Эмчилгээ хэрэгтэй	ДОХ-той хүн илүү амархан сүрьеэтэй болдог ба энэ нь түүнийг үхэлд хүргэж болно.



## ДОХ-той хүмүүсийн ажлын байран дахь эрх



Ялгаварлан гадуурхал (ажил эрхлэлт бас ажил мэргэжил)-ын эсрэг конвенц (№111), Нийгмийн аюулгүй байдлын тухай конвенц (№102), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн конвенц (№155), ОУХБ ДОХ ба ХДХВ-ийн зөвлөмж (№200)-д ажил олгогчид нь ажлын байран дахь ДОХ болон ХДХВ-д анхаарлаа хандуулах ёстой гэсэн байдаг:

- ДОХ, ХДХВ-ийн улмаар учирч болох ажлын байрны асуудлуудыг тодорхойлох;
- Ажил дээр ДОХ-ын тархалтын нөлөө болон тархалтыг зогсоох алхмуудыг хийх;
- ДОХ-той амьдарч байгаа ажилчдын эсрэг ялгаварлан гадуурхлыг арилгах. Ажил хайгчдаас ДОХ-ын шинжилгээ өгөхийг шаардах ёсгүй ба ажилчин ажлаа алдах үндэслэл нь ДОХ-той гэсэн шалтгаан байж болохгүй;
- Бүх ажилчдыг эрүүл, аюулгүй ажлын орчноор хангаж, ДОХ-той амьдарч байгаа ажилчдын хэрэгцээнд аль болох чадахаараа тусал;
- ДОХ-оос урьдчилан сэргийлэх мэдээлэл болон боловсролд анхаарлаа хандуул;
- ДОХ-той ажилчдад эмчилгээ хийх үйлчилгээг багтаасан эрүүл мэндийн үйлчилгээ санал болго;
- ДОХ-ын эмчилгээ, үйлчилгээ, дэмжлэг авах боломжийг хөнгөвчил

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага, НҮБ, ОУХБ-ын үүргийг Хавсралт А-д тайлбарлав.

## Үйлдвэр дэх ДОХ-ын хөтөлбөрүүд

Танай бүлэг эсвэл үйлдвэрчний эвлэл нь ажил дээр болон олон нийтийн дунд ДОХ яаж тархдаг, бас урьдчилан сэргийлэх боломжийн талаар ажилчдад боловсрол олгож чадна. Танай гишүүд ДОХ-ын талаарх ташаа мэдээллийг эсэргүүцэх үйлдэл хийх талаар сурч, үнэгүй бэлгэвч тараах, ДОХ-ын шинжилгээ, бас эм санал болгох үйл ажиллагааг сурталчилж чадна. Та ДОХ-той хүмүүсийг эмчилгээ хийлгэх, үйлчилгээ авах боломжтой болгосноор тэд удаан, эрүүл амьдарч, бас нийгэмдээ хувь нэмрээ оруулж чадна.

## Ажилчдын дундаас сургагч бэлтгэх сургалт

Эрүүл мэндэд тохирсон технологи (PATH) гэх хөтөлбөр нь үйлдвэрт биднийг сургалтад хамруулж ДОХ-ын сургагч болгон бэлтгэсэн. Бид урьдчилан сэргийлэх арга, ДОХ-ын шинжилгээ, бас бэлгэвчний талаар сурч мэдсэн юм. Үйлдвэрийн урд талд бэлгэвч тараах, хэрхэн хэрэглэхийг нь тайлбарлах, орон нутгийн ДОХ-ын хөтөлбөрийн талаарх товхимол тараах зайг байгууллага гаргаж өгсөн. Заримдаа хотод байгаа ажиллагчдын гэр бүлийнхэнд мэдээлэл өгдөг.



## Ажлын байрны хөтөлбөр

Зарим хөтөлбөр нь ажил олгогчдод ажилчдыг эрүүл байлгаснаар ямар ашиг тустай байхыг харуулахад төвлөрдөг. Бусад нь ажилчдын эрүүл мэндэд анхаардаг. Олон хүн ДОХ-той байгаа газарт ДОХ-ын хөтөлбөр нь ажил дээрх үйлдвэрлэл, бүтээгдэхүүний чанарыг зохицуулахад анхаардаг нь илэрхий.

Үйлдвэр дэх ДОХ-ын хөтөлбөрт дараах зүйлсийг нарийвчлан багтаана:

- Үнэгүй, бас нууцлалтай ДОХ-ын шинжилгээ эсвэл ажилчдад шинжилгээ өгөхөд шаардагдах чөлөө олгох;
- ДОХ-ын төлөв байдлыг харгалзан нууцлалтай байх;
- ДОХ-той ажилтныг ялгаварлан гадуурхахыг хориглох журам;
- Аюулгүй байдал, эрүүл ахуйн дадлага олгох сургалт нь осол гарсан үед халдвар авах эрсдэлийг бууруулдаг. Хэрэв ослын үеэр цус гарч, түүнд өртсөн бол үйлдвэр нь ӨДҮС (өртөлтийн дараах урьдчилан сэргийлэлт)-ээр ДОХ-той хүний эмчилгээг хүртээмжтэй байлгах;
- ДОХ-той ажиллагчдад эрүүл мэнддээ анхаарах эсвэл гэр бүлийнхнийхээ эрүүл мэндэд анхаарал тавихад зориулсан чөлөө олгох;
- Үнэгүй бэлгэвч тараах зэргээр аюулгүй бэлгийн хавытлыг дэмжих;
- Эрүүл мэндийн үйлчилгээг ДОХ-ын талаарх зөвлөгөө, шинжилгээ, эмчилгээг багтаан бүх ажилчид болон тэдний гэр бүлд үзүүлэх;

- Сүрьеэгийн шинжилгээ, эмчилгээ ба урьдчилан сэргийлэлтийг байнга хийх. Учир нь ДОХ-той хүмүүс сүрьеэтэй болох нь нийтлэг байдаг. (31-р бүлгийг үз).

### Үйлдвэр ART-ийн үнийг төлдөг

Волксваген машин үйлдвэрлэдэг компани нь 1996 онд Бразилд ДОХ-ын халдвартай менежерүүд, ажиллагчдын тоо их өсөж байсанд хариу арга хэмжээ болгож, ДОХ-ын хөтөлбөрийг эхлүүлсэн байдаг. Бусад ДОХ-ын хөтөлбөртэй нэгэн адил энд ДОХ-ын шинжилгээ багтдаг байв. Эерэг хариу гарсан хүмүүст Волксваген компани эмнэлгийн тусгай үйлчилгээ, үнэгүй эм, эмнэлгийн ART-ын эмчилгээний үзлэг, гэр бүлийн хalamж болон өвчний дараа ажилдаа эргэн ирэхэд нь туслах зэргийг багтаасан эмчилгээний багцыг санал болгож байв.

Волксваген компанийн хөтөлбөрт шинжилгээ, эмчилгээ, бас ажиллагчдын гэр бүлийг дэмжих зэрэг үйлчилгээ багтдаг байв. Энэхүү дэмжлэг туслалцаатайгаар ДОХ-той ажиллагчдынх нь 90 хувь нь ямар нэгэн өвчний шинж тэмдэггүйгээр идэвхтэй ажлаа хийсээр байна. Хөтөлбөрийн бас нэг хэсэг нь хүчтэй боловсролын нөлөө байв. Ажилчид ДОХ-ын талаар сургалтад уригдаж, мэдээллээ хамтран ажиллагчдадаа түгээхэд дэмжлэг үзүүлдэг байв. Олон байгууллага ДОХ-ын хөтөлбөр эхлүүлбэл ART худалдан авахад өндөр зардал гарна гэж айдаг ч энэ хөтөлбөр үнэн хэрэгтээ шинэ хүн үргэлж авч байхын оронд ДОХ-той ч ур чадвартай хүмүүсээ байлгаснаар илүү их мөнгө хэмнэх боломжийг олгодог юм.